



**БАТЛАВ:ХАТАНБУЛАГ СУМЫН  
ЗАСАГ ДАРГА С.ЭРДЭНЭБОЛД**

**ХАТАНБУЛАГ СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

2020 оны 03 дугаар сарын 27-ний өдөр

**Төслийн нэр: “БАГА ОВРЫН КОВШ” БАРАА НИЙЛҮҮЛЭХ ТЕНДЕРИЙН БИЧИГ  
БАРИМТ**

**Төслийн дугаар: ХБ-НТШ-2020/01**

Хатанбулаг сум  
2020 он

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо<sup>1</sup> : 2020.03.27  
Тендер шалгаруулалтын нэр:Бага оврын ковш  
Тендер шалгаруулалтын дугаар: ХБ-НТШ-2020/01

**[Хатанбулаг сумын ЗДТГ]** эрх бүхий тендерт оролцогчдоос **[Бага оврын ковш]**-ыг нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэлээр нь **[дүн]**<sup>2</sup> төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **[30]** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

Борлуулалтын хэмжээ: Төсөвт өртөгийн 80%-иас дээш  
Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:  
Төсөвт өртөгийн 80%-иас дээш  
Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2019 оноор  
Сүүлийн 1 жилд хэрэгжүүлсэн 2-3 ижил төстэй ажлын өртөг нь төсөвт өртөгийн  
80 хувиас дээш байх.  
Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: үгүй

Тендерийн хамт **[1,500,000]**<sup>3</sup> төгрөгийн дүнтэй 2%-ийн тендерийн баталгаа<sup>4</sup> ирүүлнэ.

Тендерийг **[2020.04.27-ны 10:00]**-аас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **[2020.04.27]-ны өдрийн, [10:30]**<sup>5</sup>-т нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх:<sup>6</sup> **Үгүй**  
Дотоодын давуу эрх тооцох эсэх.<sup>7</sup> Тийм

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар авч болно.

Дорноговь аймаг Хатанбулаг сумын  
Засаг даргын тамгын газар 203 тоот  
Засаг даргын орлогч гэсэн хаягаар ирүүлнэ.  
Утас: 89173003,95514343  
Имейл:zulchimedtsere@yahoо.com

<sup>1</sup> Тендерийн урилгыг анх зарлан мэдээлсэн өдөр байна.

<sup>2</sup> Тендерийн баримт бичгийг түүнийг бэлтгэхэд буюу хувилж олшруулах, шуудангаар хүргэх зэрэгт зарцуулсан өртгөөр үнэлж, тендер шалгаруулалтад оролцохыг хүсэгчдэд энэ үнээр саадгүй олгоно.

<sup>3</sup> Төсөвт өртгийн 1-2 хувьтай тэнцүү байна.

<sup>4</sup> Барааны төсөвт өртөг 30 сая төгрөгөөс дээш бол, тендерийн баталгаа ирүүлэхийг заавал шаардана.

<sup>5</sup> Тендер хүлээн авах эцсийн хугацаа дууссанаас хойш 1 цагийн дотор байна.

<sup>6</sup> Гадаадын этгээдийг худалдан авах ажиллагаанд оролцуулахгүй бол “Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй” гэж бичнэ.

<sup>7</sup> Захиалагч тендер шалгаруулалтад давуу эрхийн зөрүү хэрэглэхгүй бол, энэ өгүүлбэрийг хасч оронд нь “Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү тооцохгүй” гэж бичнэ.

## ТЕНДЕРИЙН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, **[тендерт оролцогчийн нэрийг оруул]**, энэхүү тендерийн баримт бичгийн шаардлагад нийцсэн **[бараа болон бусад үйлчилгээний нэрийг оруул]**-г **[тендерийн үнийг тоогоор болон үсгээр оруул]** төгрөгөөр тендерийн баримт бичигт заасан бараа нийлүүлэлтийн хуваарийн дагуу нийлүүлэхээр санал болгож байна.
2. Бидний тендер шалгарсан тохиолдолд гэрээнд заасан барааг гэрээ байгуулснаас хойш **[тоо]** хоногийн дотор нийлүүлнэ. Энэ нь техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарьт үндэслэнэ.
3. Бидний санал болгож байгаа тендер шалгарсан тохиолдолд дараах үнийн хөнгөлөлт **[үзүүлнэ эсхүл үзүүлэхгүй гэдгийн аль нэгийг оруулах]** **[Үнийн хөнгөлөлт үзүүлэхээр бол техникийн тодорхойлолтонд дурдсан бараа болон бусад үйлчилгээний аль хэсэг, нэр төрөлд эсхүл бүхэлд нь ямар хөнгөлөлт үзүүлэх саналтай байгаа, үнийн хөнгөлөлт тооцох аргачлалыг хэрхэн хэрэглэх талаарх саналаа оруул]** үзүүлнэ.
4. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер нээснээс **[тоо]** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
5. Бид, энэхүү тендер шалгаруулалтаар нийлүүлэгдэх бараа, түүнийг дагалдах бусад үйлчилгээний техникийн тодорхойлолт болон бусад баримт бичгийг бэлтгэсэн, эсхүл гэрээний хэрэгжилтийг хянах, зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр нэр нь дэвшигдсэн этгээд болон үнэлгээний хорооны гишүүдтэй нэгдмэл сонирхолгүй болохоо мэдэгдэж байна.
6. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
7. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий этгээдийн гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:



## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- |   |  |
|---|--|
| <b>1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа</b> | <b>1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.</b>   |
| <b>2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт</b>               | <b>2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.</b><br><b>2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.</b>   |
| <b>3. Тендерийн иж бүрдэл</b>                           | <b>3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:</b><br><b>3.1.1 Үнийн санал; Бараа нийлүүлэх тендерийн жишиг бичиг баримтын маягтаар</b><br><b>3.1.2 Оролцогч компанийн танилцуулга</b><br><b>3.1.3 Бараа нийлүүлэх хуваарь;</b><br><b>3.1.4 Чадварын мэдээлэл болон бусад баримт бичиг;</b><br><b>3.1.5 Ижил төрлийн бараа, нийлүүлсэн туршлага гэрээ холбогдох тайлангийн хуулбар, хүлээлгэн өгсөн акт 2019 онд 2-3 төрлийн бараа</b><br><b>3.1.6 Санхүүгийн аудитаар баталгаажсан тайлан сүүлийн 1 жил буюу 2019 оноор</b><br><b>3.1.7 Шаардлагатай тусгай зөвшөөрөл “шаардахгүй”</b><br><b>3.1.8 Улсын бүртгэлийн гэрчилгээний баталгаажсан хуулбар /гадаад худалдаа эрхлэх/ чиг үүрэгтэй байх.</b><br><b>3.1.9 Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл</b><br><b>3.1.10 Харьяалагдах банкны тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх</b><br><b>3.1.11 Татварын тайлан /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх</b><br><b>3.1.12 Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт /өргүй байх/</b><br><b>3.1.13 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт, шүүхийн төрөлжсөн архивын лавлагаа хуулбарласан тохиолдолд нотариатаар баталгаажуулах.</b><br><b>3.1.14 Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагын мэдээлэл 2019 онд 2-3 ижил төрлийн бараа нийлүүлсэн байх.</b> |
| <b>4. Тогтмол үнэ</b>                                   | <b>4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.</b>  |
| <b>5. Техникийн тодорхойлолт</b>                        | <b>5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах</b>   |

ба арилжааны нөхцөлүүд	үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
	5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа	6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 45 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх	7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
	7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь ТШӨХ-д заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
	7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл	8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. **ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

<p><b>ТӨӨЗ-ны холбогдох заалт</b></p>	<p><b>Шалгуур үзүүлэлт</b></p>
<p><b>ТӨӨЗ 1.1</b></p>	<p>Сүүлийн <b>1</b> жилийн санхүүгийн тайлан /аудитын дүгнэлтийн хамт/; Сүүлийн <b>1</b> жилд гүйцэтгэсэн <b>2-3</b> ижил төрлийн бараа нийлүүлсэн туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар, хүлээлгэн өгсөн акт/; Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: Шаардахгүй</p>
<p><b>ТӨӨЗ 2.1</b></p>	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Байгууллагын хаяг: <b>Хатанбулаг сум 5-р баг ЗДТГ</b>  Давхар болон өрөөний дугаар: <b>Хатанбулаг сумын ЗДТГ-ын 2 давхарт 203 тоот өрөө</b>  Огноо: <b>2020 оны 04 дүгээр сарын 27-ны өдөр</b>  Цаг: <b>10 цаг 00 минут</b></p>
<p><b>ТӨӨЗ 2.1</b></p>	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: <b>Хатанбулаг сум 5-р баг ЗДТГ</b>  Давхар болон өрөөний дугаар: <b>Хатанбулаг сумын ЗДТГ-ын 2 давхарт 203 тоот өрөө</b>  Огноо: <b>2020 оны 03 дүгээр сарын 27-ны өдөр 10 цаг 30 минут</b>  Цаг: <b>10 цаг 30 минут</b></p>
<p><b>ТӨӨЗ 6.2</b></p>	<p><b>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: "багцгүй" ХБ-НТШ-2020/01</b></p>

ЗАСАГ ДАРГА

БАТЛАВ:

С.ЭРДЭНЭБОЛД

## БАГА ОВРЫН КОВШ НИЙЛҮҮЛЭХ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Техникийн тодорхойлолт /ZL 40 дүйцэхүйц/

Нэр төрөл	Техник үзүүлэлт
Марк	ZL-40-өөс багагүй
Гадна хэлбэр хэмжээ /mm/	7100*2440*3100 дүйцхүйц
Шанага өргөн /mm/	2440 багагүй
Явах өргөн /mm/	2680
Дугуй хооронд /mm/	1650
Ачих даац /кг/	3000 багагүй
Шанага хэмжээ /м3/	1.7м3-20.0м3-ээс багагүй
Ачих өндөр /mm/	3800 багагүй
Ачаатай үед ачааллах хугацаа	11
Хамгийн их хөдлөх хүч /KN/	45
Хурд /km/h/	0-35km/h
Хамгийн бага эргэх радиус /m/	6.14
Дизель моторын марк	FAW6110/weicai6108 турботой дүйцхүйц
Хүчдэл	92KW/125ps
кропп	BZZ-250 дүйцхүйц
Залгагч	ZL20.2
Дугуй марк	17.5-25
Үйлдвэрлэгдсэн он	2019 он
Техникийн байдал	Шинэ
Зориулалт	Хог болон нүүрс ачих түрэх болон газар шорооны ажлын зориулалттай трактор
Түлш зарцуулалт	8-15 мото/цаг
Дагалдах зүйлс	Ком түлхүүр багаж-1 ш, түлш болон тосны шүүр-1ш,гидрийн шингэн-15л Хөдөлгүүрийн тос-8л Домакрат-8тн 1 ш Запас дугуй 1ш Техникийн паспорт Гаалийн бичиг Нийлүүлсэн аж ахуй нэгж захиалагч талд сургалт хийн, гарын авлагаар хангах

Техникийн тодорхойлолт боловсруулсан  
Үнэлгээний хороо



## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |  |   |
|--|---|
| 1. Шалгах болон турших                             | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх                                | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх     | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.  |
| 5. Баталгаат засварын хугацаа                      | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [2] жил байна.  |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах                        | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| 7. Төлбөр  | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [Ажлын 15] хоногийн дотор шуурхай хийнэ.   |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь                         | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| 9. Алданги оногдуулах                              | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.  |
| 10. Үүргээ биелүүлээгүй -гээс гэрээг цуцлах        | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.   |

11. Маргааныг шийдвэрлэх
- 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1)
- 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.]
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)
- 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
  - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
  - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
  - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
  - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.
- Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.
3. Баталгаат засвар (ГЕН-5)
- 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.
- [ 2 жилийн баталгаат хугацаатай байна]
4. Төлбөр (ГЕН – 7)
- 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
- Гэрээний үнийн дүнгийн **100** хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>8</sup>
- 9.1. Алданги оногдуулах хувь: **[0.5%]**
- Алдангийн нийт дүн: **[10%]**

**ЗАХИАЛАГЧ**

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

**НИЙЛҮҮЛЭГЧ**

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_ сарын \_\_\_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_-наас \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>9</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;

Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]*\_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

